



# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

11.09 - 11.13



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Вакцинтай холбоотой эерэг мэдээллээс үүдэн АНУ-ын хөрөнгийн зах зээлийн ихэнх индексүүд өсөлттэй хаагдлаа. Гэхдээ технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq индекс уналттай байсан ба S&P 500 индексээс технологийн салбар хамгийн их уналттай байлаа. Мөн үл хөдлөх хөрөнгө болон бараа материалын салбар уналттай байсан бол эрчим хүчний салбар өсөлттэй байлаа.

Бямба гаригт АНУ-ын Дэд Ерөнхийлөгч асан ноён Жо Байден Ерөнхийлөгчийн сонгуульд ялахад шаардагдах 270 саналын босгыг давсныг зарласан байна. Мөн Pfizer-ийн урьдчилсан мэдээллээр ХБНГУ-ын BioNTech-тэй хамтран боловсруулж буй вакцин нь халдвараас 90% сэргийлж байгаа ба компани оны эцэс гэхэд вакциныг хязгаарлагдмал тоогоор тарааж эхлэх боломжтой гэж мэдэгдсэн нь зах зээлд эергээр нөлөөлжээ.

**Европ:** Вакцинтай холбоотой эерэг мэдээнээс үүдэн Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд дэлхийн бусад томоохон зах зээлүүдийг даган өсөлттэй байсан ч коронавирусын халдварын тоо огцом нэмэгдэж байгаа болон хөл хорионы арга хэмжээнүүд эдийн засагт сөргөөр нөлөөлж байгаатай холбоотой зах зээлийн өсөлт хязгаарлагдмал байлаа. STOXX Europe 600 индекс 5.13%-аар, DAX индекс 4.78%-аар, CAC 40 индекс 7.45%-аар, FTSE MIB индекс 6.21%-аар, FTSE 100 индекс 6.88%-аар тус тус өссөн байна.

Pfizer ба BioNTech-ээс хөгжүүлж буй вакцин нь III үе шатны туршилтад өндөр үр дүнтэй байгааг зарласантай холбоотой Европ бүсийн голлох бондын өгөөж, тэр дундаа ХБНГУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж өндөр өсөлттэй байсан ч коронавирусын халдварын тоо, хөл хорионы арга хэмжээнүүд болон Европын Төв Банкны мэдэгдлүүдтэй холбоотой өгөөжүүд эргэн буурсан байна.

**Япон:** Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт дахин өсөлттэй хаагдлаа. Nikkie 225 индекс 1,061 нэгжээр буюу 4.36%-аар өсөж 25,385.87 нэгж хүрсэн нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 7.3%-аар өссөн үзүүлэлт болсон байна. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг large-cap TOPIX болон TOPIX small индексүүд өсөлттэй байсан ч энэ оны эхэн үетэй харьцуулахад бууралттай байгаа юм.

Япон улсад бүртгэлтэй компаниудын 30-аас илүү хувь нь эхний хагас жилийн (IV-IX сар) үзүүлэлт дээр үндэслэн 2021 оны 3-р сараар төгсгөл болох санхүүгийн жилийн орлогын таамаглалаа нэмэгдүүлсэн байна.

**БНХАУ:** БНХАУ-ын ихэнх компаниудын тайлан хүлээлтээс дээгүүр байсан ч макро зах зээлийн сөрөг мэдээлэл хөрөнгийн зах зээлийн индексүүд бага зэрэг бууралттай хаагдахад нөлөөллөө. Shanghai Composite индекс 0.1%-аар, large-cap CSI индекс 0.6%-аар тус тус буурсан байна. Харин 10-р сарын гадаад худалдааны үзүүлэлтүүд эерэг гарсан нь эдийн засгийн сэргэлт үргэлжилж байгааг илтгэсэн ба БНХАУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 6 нэгжээр нэмэгдэж 3.28% хүрсэн байна. Төрийн өмчит Yongcheng Coal & Electricity дефолт зарласантай холбоотой хөрөнгө оруулагчид компанийн бондуудаа их хэмжээгээр зарж эхэлсэн нь БНХАУ-ын мөнгөний зах зээлд сөргөөр нөлөөлсөн тул Төв банкнаас санхүүгийн системийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд арга хэмжээ авахад хүргэжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,503.16	-0.08% ▼
Dow Jones	АНУ	29,479.81	4.08% ▲
S&P 500	АНУ	3,585.15	2.16% ▲
Nasdaq	АНУ	11,829.29	-0.55% ▼
S&P/TSX	Канад	16,675.64	2.41% ▲
FTSE 100	Их Британи	6,316.39	6.88% ▲
S&P/ASX 200	Австрали	6,405.20	3.47% ▲
Nikkei 225	Япон	25,385.87	4.36% ▲
Hang Seng	Хонг Конг	26,156.86	1.73% ▲

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	3.62%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.33%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.20%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	1.79%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.09%
DBM' 2023	USD	7.250%	4.66%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	10.26%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	3.99%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.136	0.01 ▲
Libor 3M	0.222	0.02 ▲
Libor 6M	0.246	0.00 ▲
Libor 1YR	0.339	0.01 ▲
US 2YR Bond	0.175	0.02 ▲
US 3YR Bond	0.229	0.03 ▲
US 5YR Bond	0.403	0.05 ▲
US 10YR Bond	0.900	0.09 ▲

Валютын ханш	2020.11.13	Өөрчлөлт
USD	2,849.48	-0.01% ▼
CNY	430.58	0.08% ▲
EUR	3,366.80	-0.22% ▼
RUB	36.92	-0.03% ▼
KRW	2.56	0.79% ▲
JPY	27.12	-1.56% ▼
CAD	2,167.65	-0.66% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,889.20	-3.18% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	24.67	-3.67% ▼
Зэс	USD/lb.	318.50	0.98% ▲
Нүүрс	USD/MT	62.70	0.37% ▲
WTI газрын тос	USD/bbl.	40.13	8.05% ▲
Brent газрын тос	USD/bbl.	42.78	8.44% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.IX	1.70%
Бодлогын хүү	2020.IX	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.IX	8.22%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.IX	10.75%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.IX	3.76%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.IX	16.91%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.IX	10.46%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 41 компанийн 651.8 сая төгрөгийн 4,007,218 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монгол алт” /MSE: ERS/ компанийн хувьцаа 14.94%-аар буюу хамгийн ихээр өсөж 7,270.00 төгрөг хүрч хаагдсан бол “Хөх ган” /MSE: HGN/ компанийн хувьцаа 13.11%-аар буурч 65.50 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээл мөн ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

11-р сарын 13-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,584.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,503.16 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.08% -аар буурсан байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	651.8	
Зах зээлийн үнэлгээ	2,584,251.1	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,503.16	-0.08% ▼
MSE I индекс	8,032.14	0.12% ▲
MSE II индекс	7,358.42	0.16% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Түмэн шувуут	1,880,260	274,308,031
Ард даатгал	262,181	191,895,386
Мандал даатгал	1,003,346	47,361,689
АПУ	77,258	44,636,185
Ард санхүүгийн нэгдэл	12,775	17,906,202

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол алт	7,270.00	14.94% ▲
Хөвсгөл алтандуулга	664.95	7.95% ▲
Ард кредит ББСБ	70.00	7.38% ▲
Бөхөг	1,500.0	5.86% ▲
Хишиг уул	470.00	4.44% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Хөх ган	65.50	-13.11% ▼
УБ-БҮК	400.00	-9.09% ▼
Ремикон	23.61	-6.64% ▼
Талх чихэр	14,120.00	-5.87% ▼
Адуун чулуун	950.00	-5.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	762,876,087
Голомт Капитал	277,401,332
БиДиСек	72,862,204
Апекс Капитал	69,195,174
Стандарт Инвестмент	37,783,323

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	585.00	622,546.21
Таван толгой	5,805.00	305,721.49
МИК холдинг	11,000.00	227,802.52
Инвекор ББСБ	2,909.00	208,656.51
Говь	190.66	148,736.25

### Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-нд ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-нд ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-ны ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-нд ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-нд ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-ны ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-ны ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-нд ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-нд ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-нд ОЛГОВ
14	DSS	ДАРХАНСЭЛЭНГИЙНЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-ны ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-нд ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-нд ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-нд ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-ны ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-нд ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-нд ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-нд ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-ны ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-нд ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-нд ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-ны ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-нд ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙДОТОР
35	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	530.2	65.1	12.3%	6.3	2020.09.09	2020.09.28-нд ОЛГОВ
36	APU	АПУ	41,168.2	39,861.6	96.8%	37.5	2020.09.02	2020.11.02-нд ОЛГОВ



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



### ОНЦЛОХ МЭДЭЭ

Монгол Улсын Засгийн газар Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу Монгол Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжих шийдвэрийг гаргасантай холбогдуулан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь зайнаас ажиллах горимд шилжих бөгөөд үнэт цаасны арилжаа онлайн горимоор хэвийн явагдана.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

**“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD; MSE: ERDN/ ХК III улирлын санхүүгийн тайлангаа танилцууллаа.**

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD; MSE: ERDN/ ХК нь нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн талаар мэдээлж байна. Компанийн SEDAR-т бүртгэгдсэн 2020 оны 3-р улирлын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлан (“MD&A” буюу “Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ”) нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй нэг хэсэг болно.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Бид 3-р улиралд Баян Хөндий Алтны Төслийн (“Баян Хөндий” эсвэл “БХ”) хөгжүүлэлт болон Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий нөөцийг тэлэх гол зорилтуудын хүрээнд үр дүнтэй ажиллалаа.”

“Нарийвчилсан ТЭЗҮ-д өндөр агуулга бүхий Баян Хөндийн ил уурхай нь уламжлалт боловсруулалтын аргаар олборлох, эдийн засгийн хувьд эерэг үр дүнгүүдийг танилцуулсан. 2020 оны 8-р сард татан төвлөрүүлсэн 20 сая кан.долларын хөрөнгө оруулалт болон Канадын Экспорт Хөгжлийн Агентлагтай санхүүжилтийн баримт бичигт гарын үсэг зурснаар хөгжүүлэлтэд шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд нэг алхам ойртож байна. Төслийг олборлолтын шат руу хөгжүүлэхээр бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн.”

“Нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд бид 8-р сард Хөндий Алтны Дүүрэгт нийт 18,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, нэгдүгээр үе шатны үр дүнгүүд эерэг гарлаа. Бид Баян Хөндий орд болон 2019 онд нээн илрүүлсэн Хар Морь талбайд хэд хэдэн өндөр агуулга бүхий алтны интервалуудыг огтолсон. Хоёрдугаар үе шатны 8,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг өнгөрсөн долоо хоногтэхлүүлсэн бөгөөд энэ жилийг дуустал үргэлжилнэ. Бид өнөөг хүртэл тусгай зөвшөөрлийн талбайд нээн илрүүлсэн хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайд хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлснээр Хөндий Алтны Дүүргийн нөөцийг тэлэх боломжтой гэж үзэж байна.” хэмээн танилцууллаа.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

**“Сүү” /MSE: SUU/ ХК-ийн гүйцэтгэх удирдлага өөрчлөгдсөн байна.**

“Сүү” /MSE: SUU/ ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 10-р сарын 28-ны өдрийн 14 тоот тогтоолоор тус компанийн Гүйцэтгэх захирал Мэндбаяр овогтой Мандхайг 2020 оны 10-р сарын 28-ны өдрөөс эхлэн албан тушаалаас нь чөлөөлж, түр орлон гүйцэтгэгчээр Доржготов овогтой Эрдэнэчимэгийг томилсон байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

**Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэгдлээ.**

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 10-р сарын 21-ний өдрийн 938 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 11-р сарын 12-ны өдрийн А/75 тоот тушаалаар “Инвектор актив ТЗК” ХХК-ийн гаргаж буй доорх нөхцөлтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ.

- Үнэт цаасны нэр: Инвектор актив ХБҮЦ
- Үнэт цаасны тоо ширхэг: 10,000 ширхэг
- Үнэт цаасны нэрлэсэн үнэ: 400,000 төгрөг
- Үнэт цаасны нийт үнийн дүн: 4,000,000,000 төгрөг
- Үнэт цаасны хүү/өгөөжийн хувь хэмжээ: Жилийн 16.4%
- Үнэт цаасны хугацаа: 24 сар
- Үнэт цаасны хүү төлөгдөх хугацаа /давтамж/: 3 сар тутамд

Ийнхүү, Монголын хөрөнгийн хөрөнгийн зах зээлд дахин нэгэн шинэ төрлийн бүтээгдэхүүн нэвтэрч, хөрөнгө оруулагчид тогтмол хүү төлдөг, хадгаламжийн дундаж хүүгийн хэмжээнээс өндөр бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах боломж нээгдлээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

2021 оны Төсвийн тухай хуулийн төслийг УИХ хэлэлцэж 86 хувийн саналаар баталлаа. Гэхдээ төсвийн эхний хэлэлцүүлгүүдээр төсөөлж байснаас өөр нөхцөл байдал үүссэн тул төсвийн тодотголыг удахгүй хийхээр төлөвлөжээ.

“Цар тахлын тухай хууль, батлагдсан төсөвтэй уялдуулж, цаашдын нөхцөл байдал, дүр зургийг харж байж төсвийн тодотголыг оруулж ирнэ” гэж Сангийн сайд хэлэв. Мөн тэрээр зэс, нүүрсний экспорт хэвийн явагдаж байгаа бөгөөд нүүрс ачсан 1,503 автомашин Пүрэв гарагт гарсан гэсэн мэдээлэл өглөө. Мөн зэс, нүүрсний үнийн түвшин хэвийн байгааг хэлсэн юм. Засгийн газар 50.6 сая ам.долларын зээлийг вакцинд зарцуулахаар төлөвлөжээ. Энэхүү зээлийн хүсэлтээ Дэлхийн банканд тавьсан байна. Гурав хоногийн дараа Дэлхийн банкны Захирлуудын зөвлөл зээлийг хэлэлцэж батлах юм байна. Хүн амын 60 хувиа вакцинжуулахаар төлөвлөжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс хойш Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг дараах 4 чиглэлээр танилцуулж байна. Үүнд:

#### 1. Банкуудын үйл ажиллагаатай холбоотой

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 11-р сарын 11-17-ны өдрийн хооронд Гамшгаас хамгаалах хуулийн дагуу улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжих шийдвэр гаргасан.

Үүнтэй холбогдуулан арилжааны банкуудын зүгээс нийтийн эрүүл мэндийг хамгаалах, коронавируст цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг салбар, нэгжүүдээ ажиллуулахгүй байхаар шийдвэрлэсэн. Харин орон нутаг дахь арилжааны банкны салбар, нэгж нь өөрийн харьяалах нутгийн захиргааны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. Банкууд үйл ажиллагаа явуулахгүй байгаа газруудад бэлэн мөнгөний орлого, зарлага, шилжүүлгийн гүйлгээ банкны салбараар түр хугацаанд хийгдэхгүй.

Гэхдээ Монгол Улсын төлбөрийн системийн үйл ажиллагаа болон банкуудын бүх төрлийн цахим үйлчилгээ тасралтгүй, хэвийн үргэлжилж байна. Иймд мөнгө шилжүүлэх, төлбөр тооцоо хийхдээ төлбөрийн карт, интернет, мобайл банкны үйлчилгээг ашиглах бүрэн боломжтой юм.

#### 2. Банкны төлбөр тооцоог хэвийн үргэлжлүүлэх чиглэлээр

Монголбанкны зүгээс төлбөр тооцоог бэлэн бус хэлбэрээр хийхэд ямар нэгэн хүндрэл үүсэхгүй гэж үзэж байна. Одоогоор дотоод төлбөр тооцоо саатсан, тасалдсан тохиолдолд гараагүй байна.

Төлбөрийн системээр хийгдсэн гүйлгээ сүүлийн 3 өдөр буурах хандлагатай байна. Тухайлбал, 11-р сарын 10-ны өдөр 850 мянган картын гүйлгээ (22 тэрбум төгрөг) хийгдэж байсан бол 13-ны өдөр 565 мянга болж буурлаа. 11-р сарын 10-ны өдөр бага дүнтэй (3 сая төгрөг хүртэл) 244 мянган гүйлгээ хийгдэж байсан бол 13-ны өдөр 149.3 мянга болж буурлаа. Харин их дүнтэй (3 сая төгрөгөөс дээш) гүйлгээ 3.9 мянгаас 3.4 мянга болж өөрчлөгдлөө.

#### 3. Гадаад төлбөр тооцоог хэвийн гүйцэтгүүлэх чиглэлээр

Арилжааны банкуудын төв оффис ажиллаж, гадаад төлбөр тооцооны хувьд гүйлгээний хэвийн явагдаж байна. Банкууд гадаад төлбөр тооцоог уян хатан байдлаар зохицуулан ажиллаж байна. Тодруулбал, иргэд, аж ахуйн нэгж харилцагч банкныхаа харилцах үйлчилгээний лавлах утсаар холбогдож, нэмэлт заавар, лавлагаа авах замаар гадаад төлбөр тооцоогоо хийж байгаа болно. Жишээ нь, 11 дүгээр сарын 12-ны өдөр 476 удаагийн гүйлгээгээр нийт 70.6 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаад улсууд руу төлбөр шилжүүлсэн бол 638 удаагийн гүйлгээгээр 95.6 тэрбум төгрөгийн гадаад гүйлгээний орлого хүлээн авчээ.

#### 4. Бодлого, зохицуулалтын чиглэлээр

Зээлийн хуваарьт өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлаар тодруулга, мэдээлэл өгөхөд зээлийн эргэн төлөлтийг банкуудтайгаа тохироод хойшлуулах зохицуулалт энэ оныг дуустал үргэлжилж байгаа болно.

Иймд Ковид-19 цар тахлаас үүдэн орлого, үйл ажиллагаанд хүндрэл үүссэн иргэд, аж ахуйн нэгжүүд харилцагч банкиндаа хандан зээлдээ бүтцийн өөрчлөлт оруулах асуудал нээлттэй байгаа болно.

Нөхцөл байдал одоогийн байдлаас хүндэрч, эдийн засаг, санхүүгийн салбарт ноцтой хүндрэл бий болох дохио гарах тохиолдолд Монголбанк ээлжит шат дараатай бодлогын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх болно.

Монголбанкны зүгээс бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхээс аль болох зайлсхийж, гарцаагүй тохиолдолд АТМ машин ашиглах, банкны салбар, нэгжээр үйлчлүүлэх бол хорио цээрийн дэглэмийг чанд баримтлан, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж, хоорондын зайг барьж, бөөгнөрөл дараалал үүсгэхгүй байх зөвлөмж гарган мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж байна. Түүнчлэн энэ чиглэлээр банкууд ч идэвхитэй хамтран ажиллаж байгаа болно.

Эх сурвалж: Монголбанк

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

**БНХАУ-ын зэс, хөнгөн цагааны импорт I-X сард огцом өсөж, никелийн импорт буурав.**

БНХАУ-ын зарим металлуудын импорт өсөж, өмнөх санхүүгийн хямралын үеийн түвшинтэй ойртлоо. Тухайлбал: тус улсын боловсруулаагүй зэсийн импорт оны эхний 10 сард 5.6 сая тонн болж, өмнөх онуудын жилийн эцсийн үзүүлэлтийг давлаа. Зэсийн үнэ буурч, эдийн засаг сэргэж байгаа нь үүнд голлон нөлөөлжээ.

Оны эхээр цар тахлын улмаас хөл хорио тогтоож эхлэхэд, Лондоны Металлын биржид зэсийн үнэ огцом унаж тонн нь 4,371 ам.доллар болсон юм. Үүний дараа БНХАУ зэсийн худалдан авалтаа эрчимтэй нэмсэн аж. Улмаар эрэлтээ дагаад зэсийн үнэ сүүлийн хоёр жилийн дээд түвшинд хүрч өсөөд байна.

Лхагва гарагийн байдлаар фьючерс үнэ тонн нь 6,932 ам.доллар хүрээд байгаа юм. Түүнчлэн БНХАУ-ын хөнгөн цагаан болон хөнгөн цагааны хайлшны импорт зургаадугаар сараас хойш тогтвортой өсөж байна. Тус улс I-X сард нийт 766 мянган тонн хөнгөн цагаан импортолжээ. Харин хөнгөн цагааны хайлшны импорт 932 мянга тонн болжээ.

БНХАУ энэ хугацаанд мөн 358 мянган тонн цайр импортолсон байна. Энэ нь жилийн өмнөхөөсөө 25 хувиар буурсан дүн боллоо. Тус улсын цайрын нийлүүлэлт Өмнөд Америкт тогтоосон хязгаарлалтуудаас болж буурсан гэж шинжээчид дүгнэж байна.

Нөгөө талаас 2060 он хүртэл хүлэмжийн хийн ялгаруулалтаа бууруулах зорилт тавиад буй БНХАУ-ын никелийн импорт энэ хугацаанд 40 хувиар буурч, 2008 оноос хойших хамгийн доод түвшинд хүрчээ. Цэнэг хураагуурын гол түүхий эд болох никелийн импорт өмнөх санхүүгийн хямралын дараа хоёр дахин өсөж байсан бол энэ удаа буурсан байна.

Лхагва гарагийн байдлаар хөнгөн цагааны фьючерс үнэ 0.77 хувиар өсөж, тонн нь 1908 ам.доллар боллоо. Харин цайрын үнэ 0.13 хувиар өсөж, тонн нь 2645 ам.доллар болсон бол никелийн үнэ 0.32 хувиар буурч, тонн нь 15.7 мянган ам.доллар болоод байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



**Sxcoal.com: БНХАУ-д коксжих нүүрсний үнэ өсөх төлөвтэй.**

БНХАУ-ын хойд мужуудад 2020 оны сүүлийн саруудад коксын үйлдвэрлэл буурч, түүнийг дагаад коксжих нүүрсний үнэ өсөж магадгүй гэж "Sxcoal"-ийн шинжээчид таамаглалаа. Шанси, Хэбэй мужийн зарим хот коксын гарцаа бууруулахаар шийдвэрлэсэн. Тухайлбал, Шанси мужийн Сяо хотод 4.3 метрийн өндөртэй зуухнуудаа оны эцэс гэхэд хаах шийдвэр гаргажээ. Тус хотын ийм төрлийн зууханд жилд 4.7 сая тонн кокс үйлдвэрлэдэг аж. Үүнтэй ижил төстэй шийдвэрүүд бүсийн хэмжээнд гарсаар байна.

Түүнчлэн БНХАУ-ын Үндэсний нүүрсний уурхайн аюулгүй ажиллагааны газар уурхайн осол эндэгдлээс сэргийлэхийн тулд орон нутагт тавих хяналтаа чангатгасан. Энэ нь нүүрсний олборлолт буурахад нөлөөлж, коксжих нүүрсний үнэ өсөж магадгүй гэж "Sxcoal"-ын шинжээчид үзлээ.

Мөн коксжих нүүрсний гол нийлүүлэгч орон болох Монголд "COVID-19"-ийн дэгдэлттэй холбоотой хатуу хөл хорио тогтоогоод байгааг мэдээлэлдээ дурьджээ. 2020 оны эхний 10 сард Монгол Улс 23.8 сая тонн чулуун нүүрсийг 1.77 тэрбум ам.доллараар экспортолсон. Үүний 95.2 хувийг БНХАУ-ын зах зээлд нийлүүлсэн юм. "COVID-19"-ийн тархалттай холбоотойгоор хойд хөрштэй хиллэдэг авто замын боомтуудаа хаагаад байгаа ч БНХАУ-тай хиллэдэг боомтууд хэвийн ажиллаж байна. Нүүрсний экспорт Гашуунсхайт, Шивээхүрэн, Булган, Замын-Үүдийн боомтоор хэвийн гарч байгааг ГЕГ баталгаажуулсан.

Эх сурвалж: BloombergTV.mn

### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.